

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 11/337

НШУС

2010

### ИНТЕРНЕТ-ЦЕНЗУР: МӨН ЧАНАР, ШААРДЛАГА

Ч.Чойсамба\*

\* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), дэд профессор

**Түлхүүр үг:** Интернет-цензур, Интернет-шүүлтүүр, өөрийн цензур, хил хязгааргүй сүлжээ, веб-сервер, блоггер, мэдээллийн булан, Dos-довтолгоон.

Интернет-цензур (англиар «Internet Censorship») бол Интернетийн даяар сүлжээнд нийтлэлээ байрлуулах, эсвэл нэвтрэхийг хянах, таслан зогсоох зорилго бүхий үйл ажиллагаа юм. Интернет сүлжээ улс, үндэстний ямар нэг хил хязгааргүй байдаг нь зарим орны засгийн газрын хувьд цензур буюу цагдан хяналт нэвтрүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгожээ. Гэхдээ өөрийн орны үндэсний ашиг сонирхолд харшилсан гэж үзсэн агуулга бүхий мэдээлэл өөр орны версерверт нийтлэгдэх боломжтой байдагт Интернет-цензурын нэг том дутагдал оршино.

Интернет дэх цензур нь тодорхой вебийг блоклох, хаахаар төдийгүй, мөн мэдээллийг цагдан хянах, хориотой мэдээллийг зохиосон зохиогч, түүнийг нийтэлсэн веб-серверын эзэнд залхаан цээрлүүлэх арга хэмжээ авахаар илэрдэг.

Reporters sans frontières («Хил хязгааргүй сурвалжлагчид») олон нийтийн

байгууллагын тайлангаас үзвэл 2008 онд 1740 веб-сайт блоклогдсон, эсвэл хаагдсан, Интернетэд материалаа байршуулсны төлөө 105 блоггер халдлагад өртсөний 1 нь алагдсан, 59 нь баривлагдсан, 45 нь гэмтэл, бэртэл авсан байна<sup>1</sup>.

Нэг улс техникийн хувьд дангаараа Интернет сүлжээг хяналтандаа авах ямар ч боломжгүй юм. Гагцхүү БНХАУ, БНАСАУ, ЛБНИУ зэрэг орон л үлээмж чармайлалт гаргаж байгаагийнхаа ачаар даяар сүлжээг өөрийн хяналтанд байлагж чадаж байна. Гэвч сүүлийн жилүүдэд техник, технологийн дэвшил асар хурдацтай явагдаж байгаа учир цензур хэрэгжүүлэх нэг аргыг олоход хэсэгхэн хугацааны дараа түүнийг гэтлэх шинэ арга гарч ирдэг. Эцсийн дундээ Интернет-цензурыг хэрэгжүүлэх нь үлэмж зардал шаарддаг атлаа тэр бүр тухайн орны засгийн газрын хүссэн үр дүнд хүргэдэггүй байна. Билл Гейтс нэгэнтээ: «Сүлжээгээр дамжуулж мэдээллийг чөлөөтэй түгээх явдлыг хэн нэгэн хязгаарлах гэж оролдвол дэлхий дахини хувьд аиж эмээх зүйлүүгүй гэж би бодож байна. Интернетийг цагдан хянах ямар ч боломж үгүй. Эрт орой хэзээ нэг

цагт уг хэлэх эрх чөлөө ялах болно» гэсэн нь бий.

Хэдийгээр Интернет-цензур нь хэвлэлийн цензурын нэг адил хууль цаазын үндэслэлтэй байдаг ч даяар сүлжээ өөрөө хил хязгааргүйд үндсэн ялгаа нь оршино. Хэрэв хэвлэлийг бүрмөсөн хааж болдог бол веб-сайтыг зөвхөн тухайн орны нутаг дэвсгэрийн хүрээнд л «хаадаг». Өөрөөр хэлбэл, хаагдсан веб-сайт руу өөр орны нутаг дэвсгэр дэх серверээс чөлөөтэй, ямар нэг хязгаарлалтгүй нэвтэрч болдог байна. Түүнчлэн Интернетэд Data havens буюу мэдээллийн булан байдгаас болж материалыг чухам хэн бичснийг 100 хувийн магадлалтай тогтоох, түүнчлэн сайтнаас бүрэн устгах боломжгүй байдаг. «Мэдээллийн булан» хэмээх нэр томьёо нь haven (тэнгисийн булан буюу салхинаас халхлагдсан жижигхэн гүн булан) үгээс гаралтай бөгөөд мэдээлэлд нэвтрэхийг техникийн хувьд (шифрлэн тайлах боломжгүй) хязгаарлагдсан, хууль цаазын хувьд (мэдээлэл хадгалахыг хуулиар хориглоогүй улсад байрладаг серверт хадгалсан) найдвартай хамгаалагдсан «зоорь» (компьютер буюу сүлжээ)-ийг илэрхийлдэг. Юуны түрүүнд мэдээллийн буланд:

- Интернетийн чанд цензуртэй орны оршин суугч улс төрийн өнгө аяс бүхий мэдээллийг,
- Ямар нэг байгууллагын үйл ажиллагааг шүүмжилсэн, эсвэл авлига хээл хахууль, хууль зөрчилтийг илчилсэн мэдээллийг,
- Зохиогчийн эрхийн тухай хуулийг зөрчсөн материалыг,
- Онлайн казиног,

- Садар самууныг сурталчилсан материалыг байршуулдаг.

Мэдээллийг цагдан хяналтад өртүүлэлгүй, тархмал байдалтай хадгалахын жишээ бол Freenet сүлжээ юм. Энэ бол мэдээллийн зохиогч, нийлүүлэгчийг чанд нууцлах замаар цахим мэдээллийн эрх чөлөөг хангах зорилгоор тусгайлан бүтээгдсэн сүлжээ бөгөөд гишүүддээ материал байршуулах, янз бүрийн төрлийн мэдээлэл авах боломж олгодог. Нэг өгүүлбэрээр Freenet-ыг мэдээлэл хадгалах асар том байгууламж гэж тодорхойлж болно. Хэрэглэгч мэдээллээ энэ сүлжээнд байршуулахдаа түлхүүр авдаг. Тэрхүү түлхүүрээр хэрэглэгч мэдээллээ эргүүлээд хэзээ ч авч болдог<sup>2</sup>.

**Г**эсэн хэдий ч дэлхийн олон оронд Интернет дэх мэдээллийг цензур дэх оролдлого хийгддэг. Тодорхой веб-сайтуудыг сонгож, блоклох тусгай төхөөрөмж бүтээдэг олон арван компани байдаг. Эдгээр компани цензур хэмээх үгийг хэрэглэхээс аль болохоор зайлсхийдэг бөгөөд бүтээгдэхүүнээ Интернет-шүүлтүүр гэж ямар нэг сөрөг өнгө аясгүй үгээр нэрлэдэг. Түүнчлэн хүүхдүүдэд зориулсан шүүлтүүрийг parental control software («эцэг, эхийн хяналт»), хайлтын машины хариултын шүүлтүүрийг safe search («аюулгүй хайлт») гэдэг. Интернетийг цагдан хяналтын аливаа хэлбэрээс ангид байлагахын төлөө тэмцэгчид ийм төрлийн программ хангамжуудыг цензурын программ хангамж буюу censorware гэдэг.

Даяар сүлжээн дэх мэдээллийг цензурдэх шаардлага, хэрэгцээ бий эсэх талаар эсрэг тэсрэг байр сууринууд байдаг. Хамгийн сонирхолтой нь Интернет

нетийн мэдээллийг цензурдэх анхны оролдлогыг тоталитар дэглэмтэй бус, харин ардчилсан оронд хийсэн байна. Сүлжээн дэх зарим мэдээллийн агуулга хүүхдүүдэд хортой нөлөө үзүүлэхээс эмээж болгоомжилсон эцэг эх, сурган хүмүүжүүлэгчид цензурдэхийг шаардсан байдаг.

1996 оны эхээр АНУ-ын Конгресс нь Интернетэд зүй зохисгүй, илэрхий гутаан доромжилсон өнгө аяс бүхий мэдээллийг байршуулахыг хориглосон «Мэдээлэл харилцаан дахь зүй ёсны хэм хэмжээний тухай акт» («Communications Decency Act»)-ыг боловсруулжээ. Гэвч энэхүү Акт нь АНУ-ын Үндсэн хуулийн Нэгдүгээр засвартай харшилсан тул батлагдаагүй байна. Мэдээллийг тусгай программ хангамжийн тусламжтай шүүж болох бөгөөд ингэхийн тулд заавал төрийн төвшинд цензурдэх шаардлагагүй гэсэн үндэслэлийг «Мэдээлэл харилцаан дахь зүй ёсны хэм хэмжээний тухай акт»-ыг эсэргүүцгэгчид гаргаж ирсэн юм.

Гэсэн хэдий ч дэлхийн олон оронд Интернет-цензурыг зөвхөн компани, эсвэл сургалтын байгууллагад төдийгүй, мөн төрийн төвшинд шүүдэг. Open Net Initiative и Reporters sans frontières (RSF) зэрэг олон байгууллага бие даасан судалгаа явуулж, дэлхийн янз бүрийн оронд цахим мэдээллийн шүүлт ямар төвшинд байгааг илтгэсэн статистик гаргадаг.

Reporters sans frontières (RSF) олон улсын байгууллага, мөн Оксфордын интернет-их сургуулийн дэмжлэг, санхүүжилтээр явагддаг Open Net Initiative төслөөс (Oxford Internet Institute) хийсэн судалгааны дүнг харьцуулахад харамсалтай нь Интернет-цензурын тухай нэгдмэл ойлголт, хандлага бий болоогүй байгаа нь харагддаг<sup>3</sup>. Гэхдээ судлаачдын санал нийлдэг хэд хэдэн зүйл бий бөгөөд эдгээрээс товч дурдъя. Цахим мэдээллийг шүүлтүүрээр оруулдаг орнууд дахь Интернет-цензурыг дараах маягаар ангилдаг:

Бүрэн шүүлтүүртэй орнууд. Эдгээр оронд БНХАУ, Иран, Сири, Вьетнам, Куба, БНАСАУ хамаардаг. Хятад дахь Интернет-цензур нь төрийн төвшинд хэрэгждэг бөгөөд улс төрийн өнгө аястай байдаг. «Хятадын мэдээллийн их

«Дэлхийн олон оронд Интернет дэх мэдээллийг цензурдэх оролдлого хийгддэг. Тодорхой веб-сайтуудыг сонгож, блоклох тусгай тохооромж бүтээдэг компаниуд цензур хэмээх угийг хэрэглэхээс аль болохоор зайлсхийдэг бөгөөд бүтээгдэхүүнээ Интернет-шүүлтүүр гэж ямар нэг сорог өнгө аягүй угээр нэрлэдэг.»

«

»

хэрэм» хэмээх нэр томьёо үүссэн нь энэ улсад цахим мэдээллийг хэрхэн цагдан хянадагтай холбоотой. Америкийн «The New York Times» сонинд дурдсанаар 30 гаруй мянган хүн Интернет дэх мэдээллийг цензурдэх ажлыг гардан гүйцэтгэдэг байна. Хүний эрх, улс төрийн сөрөг хүчин, Тайвань, Төвдийн тусгаар тогтолцой холбоотой аливаа мэдээлэл «хар жагсаалт»-анд ордог. Хятадад өөрийн цензур буюу self-censorship маш хүчтэй байдаг. Олон компани «Өөрийн цензурыг хэрэгжүүлж, мэргэжлийн ёс зүйгээ баримтлах олон нийтийн амлалт»

(«Public Pledge of Self-Regulation and Professional Ethics»)-ад гарын үсгээ зурдаг. Орон нутгийн провайдер, хайлтын машин, веб-форумууд сэжигтэй аливаа мэдээллийг эсвэл шүүлтүүрээр оруулдаг, эсвэл устгадаг байна. Үүний үр дүнд хятад хэрэглэгч «мэдээллийн эрх чөлөө», эсвэл «хүний эрх» гэдэг ойлголтын тайлбарыг хайлтын программаар хайгаад сайндаа л улс төрийн шүүлтүүрээр шүүгдсэн мэдээллийг олж уншдаг ажээ.

2006 оны 1-р сард Google компани хятад хэл дээр сайттын сайт нээсэн боловч БНХАУ-ын эрх баригчдын үзэж буйгаар «улс төрийн хувьд алдаа мадагтай, ташаа» мэдээлэл бүхий сайтуудад Хятадын иргэдийг нэвтрүүлэхгүй байх үүрэг хүлээжээ.

**T**үүнчлэн Хятадын хэрэглэгч Wikipedia цахим нэвтэрхий тольд нэвтрэх эрхгүй байдаг. Энэхүү хоригийг Хятадын засгийн газар «ОНМХ-ээр хүчирхийллийг сурталчлах явдалтай тэмцэх» ажлын хүрээнд тавьсан гэж зарласан нь бий.

Түүнээс гадна БНХАУ-ын төрийн бодлогыг магтан дуулдаг блоггеруудын бүхэл бүтэн арми байдаг. Тэд үүнийхээ төлөө тодорхой хэмжээний шан харамж авдаг байна.

Лалын Бүгд Найрамдах Иран Улсад 2004 онд «Интернетийн салбарт үйлдсэн гэмт хэргийг шийтгэх тухай хууль» батлагдсанаас хойш улс төрийн агуулгатай, ижил хүйстнүүдийн, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалсан сайт, блогууд цензурт өртөх болжээ. Интернетэд хориотой мэдээлэл байршуулсан блоггеруудыг хорих ялаар шийтгэж байсан тохиолдууд цөөнгүй. Түүнчлэн Барууны «гаж

соёл»-г гэтлэх ажлын хүрээнд Иран Wikipedia, мөн YouTube зэрэг түгээмэл сайтуудад нэвтрэх хэрэглэгчдийнхээ эрхийг 2006 оны 12-р сарын 3-наас эхэлж хаасан байна<sup>4</sup>. Харин 2009 оны 5-р сарын 23-наас Ираны хэрэглэгчид Facebook олон нийтийн сүлжээнд нэвтрэх эрхгүй болжээ. Ажиглагчид үүнийг ерөнхийлөгчийн сонгуультай холбож тайлбарласан бөгөөд улс оронд шинэгээл хийхээ амласан нэр дэвшигчийн нэр хүндийг хязгаарлахын тулд Махмуд Ахмадинежад захиалсан гэдэг.

Вьетнамд 2009 оны 8-р сарын сүүлээр гурван блоггер баривчлагджээ. Хүн аж төрдөггүй Парасельсийн болон Спратли арлуудыг Вьетнамынх болгохын тулд засгийн газар хангалттай чармайлалт гаргахгүй байна гэж шүүмжилсэн нь тэдний хувьд шоронгийн хаалга татах үндэслэл болжээ. Тэдэнд улс орны үндэсний аюулгүй байдалд харшилсан үйл ажиллагаа явуулсан зүйл ангиар ял тулгасан байна. 30 настай эмэгтэй блоггер дахин энэ асуудлаар байр сууриа илэрхийлэхгүй байх ам тангаралгаа өгсний дараа суллагджээ<sup>5</sup>.

2004-оныг хүртэл Кубад Интернетэд зөвхөн эмч, төрийн өндөр албан тушаалтнууд гагцхүү засгийн эрх баригчдын тусгай зөвшөөрлөөр нэвтэрдэг байв. Бусад иргэн даяар сүлжээг ашиглах гэж оролдсоныхоо төлөө хариуцлагад татагддаг байжээ. Рауль Кастрогийн үед Кубын иргэд Интернетэд нэвтрэх эрхтэй болсон ч дэд бүтэц сул хөгжсөн, мөн өндөр үнэ өртгөөс шалтгаалаад бүрэн төгс хэрэглэгч болоход хэдэн жил шаардлагатай гэдэг.

Мьянмад хүн амын 1 хувь нь л Интернетийг ашигладаг. Тэд ихэвчлэн интер-

нет-кафегээс сүлжээнд нэвтэрдэг учир Мьянмийн эрх баригчид эдгээр газрын үйл ажиллагааг чанд хяналтандaa авч, цензурддэг. Тухайлбал, цагдаагийнхан цахим шууданд чөлөөтэй нэвтэрч, интернет-блог хөтөлдөг, түүнийг уншдаг хүмүүсийг бүртгэлдээ авч, хянаж байдаг. Тодорхой судалгаа байдаггүй ч Мьянмийн наанадаж хоёр блоггер шоронд хоригдож байгаа гэж үздэг. Zarganar ник нэрээр олны танил болсон тэдний нэг нь «Наргис» далайн хар шуургын хор хөнөөлийн бичлэгийг 2008 онд блогтоо тавьсныхаа төлөө 59 жил хоригдох ялаар шийтгүүлжээ. Түүнчлэн 2007 онд олныг хамарсан үймээн дэгдэхэд Мьянмад Интернетийг бүрэн салгасан байна.

Өндөр төвшний шүүлтүүртэй орнууд. Эдгээр орны тоонд Саудын Арави, Арабын Нэгдсэн Эмирт Улс, Өмнөд Солонгос зэрэг улс ордог. Хэдийгээр Өмнөд Солонгос нь хэвлэлийн эрх чөлөөтэй орны тоонд ордог ч Хойд Солонгосыг сурталчилдаг, Чим Чен Ирийн дэглэмийн тухай зэрэг мэдээлэл нийтэлдэг веб-сайтуудыг IP-г блоклох төвшинд хориглодог байна.

Нэр төдий шүүлтүүртэй орнууд. Нэр төдий буюу зөөлөн цензуртэй оронд АНУ, Их Британи, Герман, Франц зэрэг гол төлөв өндөр хөгжилтэй улс тооцогддог. АНУ-д үндэсний төвшинд цахим мэдээллийг «Хүүхдүүдийг Интернетээс хамгаалах тухай Акт» (Children's Internet Protection Act, CIPA)-ын дагуу сургууль, номын сан зэрэг байгууллагад шүүлтүүрээр оруулдаг.

Тэгвэл Францын шүүх Yahoo!-гаас нацист, неонацист өнгө аястай аливаа мэдээлэлд нэвтрэх эрхийг тус улсын нутаг дэвсгэр дээр хязгаарлахыг шаард-

сан байдаг. Түүнчлэн Google ч Францын хууль тогтоомжийн дагуу өөрийн үйлчилгээгээ шүүлтүүрээр оруулдаг. Францын төр засгийн газрын төвшинд арьс өнгөөр ялгаварлан гадуурхсан, антисемит, неонацист агуулгатай мэдээлэлд сурагчид нэвтрэх боломжийг хаасан шүүлтүүрүүдийг ашиглаж байна.

Их Британид юуны түрүүнд хууль бус, тэдгээрийн дотор насанд хүрээгүй хүүхдүүдийг садар самуунд уруу татсан сайтуудад нэвтрэх эрхийг блоклодог. Ийм сайтуудыг Internet Watch Foundation алба гардан гүйцэтгэдэг ажээ.

Германд провайдерууд неонацист байгууллагын болон үндэстэн хоронд дайсагнал өдөөсөн агуулгатай сайтуудад нэвтрэх эрхийг хязгаарлах үүрэг хүлээсэн байдаг. Google, Lycos Europe, MSN Deutschland, AOL Deutschland, Yahoo!, T-Online, t-info зэрэг Герман дахь хайлтын ихэнх систем «Мультимедиа үйлчилгээний провайдеруудад зориулсан сайн дурын өөрийн хяналт» хэмээх гэрээнд нэгдсэн юм. Эдгээр байгууллага Германы залуучуудад хортой медиа хэрэгслийг хянах Холбооны департаментаас гаргадаг жагсаалтын үндсэн дээр веб-сайтуудыг шүүлтүүрээр оруулдаг байна.

Дам шүүлтүүртэй орнууд. Ийм оронд цахим мэдээллийг цензурдэх, шүүлтүүрээр оруулах ажлыг төр гардан гүйцэтгэдэггүй, эсвэл захиалагч нь байдаггүйгээрээ онцлогтой. Open Net Initiative байгууллагын судалгаагаар Беларусь, Кыргызстан зэрэг орон энэ ангилалд хамаарчээ. 2006 оны 3-р сард ерөнхийлөгчийн сонгуулийн кампанит ажлын үеэр сөрөг хүчний веб-сайтуудыг Dos (Denial of Service) технологиор блок-

лож байсан нь судалгаагаар тогтоогдажээ. Гэхдээ энэхүү Dos-dovtolgoon нь цахим мэдээллийн шүүлтүүрийн төрийн бодлогын илрэл байгаагүй бөгөөд тийм ч учир Беларусийг Open Net Initiative дам шүүлтүүртэй орны тоонд оруулсан байна. Dos-dovtolgoonyн онцлог нь хакерууд дэлхийн аль ч өнцгөөс гүйцэтгэж болдогт оршино. Гайхалтай нь Reporters sans frontieres Беларусийг Интернет-цензуртэй орон гэж үзсэн нь бий.

Хэрэв Монголыг Reporters sans frontieres байгууллага Интернет-цензур ажиглагдаагүй, тодруулбал Интернет-цензургүй орны тоонд оруулсан байдаг бол Open Net Initiative байгууллага нэр төдий (зөөлөн) шүүлтүүртэй улс гэж үзсэн байдаг. Энэ нь ч илүү үнэн бодитой байх. 2009 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Н.Энхбаярыг веб-сайтаар заналхийлсэн хүнийг Тагнуулын Төв Газрынхан илрүүлж saatuulж байжээ. Түүнчлэн 2007 онд Монголд өвлийн секс жуулчлалыг сурталчилсан цасан дээрх нүцгэн монгол охидын гэрэл зураг байршуулсан сайтыг эрх бүхий газрын шаардлагаар хааж байсан удаатай.

**Э** нэ бүгдийг өгүүлсний эцэст Интернет-цензур шаардлагатай ю? гэсэн амаргүй асуулт урган гарна. Мэдээж, хэн бүхний таалалд нийцсэн хариулт өгөх боломж үгүйг юуны түрүүнд онцлон тэмдэглэх нь зөв. Учир нь шүүлтүүр, цензурын хэлбэр, төвшин янз бүр байдаг. Хүүхдүүд, залуучуудын хүмүүжилд сөргөөр нөлөөлөхүйц цахим мэдээллийг (эх бичвэр, гэрэл зураг, бичлэг г. м.) хориглох нь зөв гэж үздэг хүн олон бий. Тэгвэл улс төрийн агуулгатай мэдээллийн цензурын хувьд хүн бүр өөрийн улс төрийн өнцгөөс

хариулт өгдөг. Үүнээс үүдээд «Бид цензурдэж байгаа бол улс үндэсний эрх ашгийг хамгаалж байна, тэд цензурдэж байвал уг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг боомилж байна» гэсэн үнэний хувьтай шог яриа ч үүсчээ.

Reporters sans frontieres байгууллааас БНХАУ, Куба, Иран, Сири, БНАСАУ, Вьетнам, Египет, Тунис, Саудын Арави, Мьянма зэрэг Интернетийн дайсан '15 орныг нэр заасан байдаг. Эдгээр нь эсвэл тоталитар дэглэмтэй, эсвэл коммунист тогтолцоотой, эсвэл лалын шашинтай, нэг үгээр тодорхойлбол ардчилал хөгжөөгүй, хэвлэлийн эрх чөлөөгүй орнууд болох нь ажиглагдана. Ийм улсын эрх баригчид иргэд нь чөлөөт мэдээллийн хэрэгсэлд нэвтрэхээс эмээх нь зүй ёсны юм. Бусад улсад цахим мэдээлэл чөлөөтэй, эсвэл харьцангуй чөлөөтэй.

Улс орон бол нэг том компани мөн. Аливаа компани имижээ зөв бүрдүүлж, хэрэглэгчдээ татаж, бараа бүтээгдэхүүнийхээ борлуулалтыг нэмэгдүүлэхийг зорьдог. Үүний нэг адил улс орон бүрт өөрийн гадаад сурталчилгааг зөв зохион байгуулж, зерэг имижээ бүрдүүлэх нь ашигтай байдаг. Ингэснээр дэлхийн тавцнаа тухайн орны нэр хүнд өсдөг. Компаниуд болзolt хэрэглэгчиддээ бараа бүтээгдэхүүнээ хүргэхийн тулд өөрийгөө сурталчлахын зэрэгцээ элдэв барцад, шүүлтүүрийг даван туулах шаардлагатай тулгардаг. Улс орнууд ч хил хязгааргүй Интернетийг ашиглаж өөрт ашигтай улс төрийн өнгө аястай мэдээллийг түгээдэг, үүний зэрэгцээ эрх ашигт нь харшилсан мэдээллийг таслан зогсоодог. Асуудалд энэ өнцгөөс хандвал Интернет-цензур нь Интернет байсан цагт байх л ёстой зүйл мэт.

Гэхдээ Билл Гейтсийн үгийг эргэн саная. Интернетийг цензурдэх нь угаасаа бүтэхгүй санаархал бөгөөд анхнаасаа нуран унах тавилантай. Учир нь Интернет улс орнуудын хоорондох хил хязгаарыг арилгаж, эцсийн дүндээ өөрийг нь цензурдэхийг оролдог тогтолцоонуудыг сөнөөх удистай.

### Ишлэл

<sup>1</sup> [http://www.rsf.org/article.php3?id\\_article=29797](http://www.rsf.org/article.php3?id_article=29797)

<sup>2</sup> П р о х о р о в А. 2007. Цензура в Интернете: «за» и «против» //«Компьютер пресс», №2.

<sup>3</sup> <http://www.ox.ac.uk/>

<sup>4</sup> <http://www.securitylab.ru/news/215636.php>

<sup>5</sup> [http://www.infox.ru/hi-tech/internet/2009/09/14/Blogyer\\_poluchil\\_svo.shtml](http://www.infox.ru/hi-tech/internet/2009/09/14/Blogyer_poluchil_svo.shtml)

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Б о л д – Э р д э н э Б. 2009. Интернет сэтгүүл зүйн үндсэн ойлголт //«Сэтгүүл зүй»

МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг №10/319.

2. Б о л д – Э р д э н э Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ.

3. П р о х о р о в А. 2007. Цензура в Интернете: «за» и «против» //«Компьютер пресс», №2.

4. К о х а н о в а Л. 2007. Интернет-журналистика. М.

### Резюме

В настоящей статье автор затрагивает проблемы Интернет-цензуры, выражающейся в контроле или запрещении материалов, которые кто-либо может публиковать в Интернете или скачивать из него. Хотя Интернет-цензура имеет ту же юридическую основу, что и цензура печати, она в основном отличается тем, что национальные границы сети размыты. Автор подробно описывает разновидности цензуры, подразделив на стран с повсеместной фильтрацией, стран с существенным уровнем фильтрации, стран с номинальным уровнем фильтрации и стран с косвенной фильтрацией.